

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
1.1 Захиалагч байгууллагын нэр, хаяг	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай
1.2 Төсөл хэрэгжих талбай	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн Ил уурхай Орхон аймгийн Баян-Өндөр сум
1.3 Ажлын нэр	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ил уурхайд уулын цулын тээвэрлэлтийн ажил гүйцэтгэх.
1.4 Ажил гүйцэтгэх үндэслэл	Эрдэнэтийн-Овоо ордын уурхайн баруун хойд хэсгийн ашиглалтыг +1040м-ийн ёроолтой уурхайгаас +905м-ийн ёроолтой уурхай руу шилжүүлэхэд шаардлагатай хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэх.
1.5 Ажлын зорилго	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрс хуулалтын ажлын төлөвлөгөөг биелүүлэх.
1.6 Ажил гүйцэтгэх үе шат, цар хүрээ	<p>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ил уурхайд хөрсний тээвэрлэлт хийх ажил нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ил уурхайд ашиглагдаж буй үндсэн техникүүд болох шууд утгуурт экскаватор ЭКГ-10, ЭКГ-12К, Либхэпп R994В, R9350 экскаваторуудаас ачилт хийлгэх, • Ордын баруун хойд хэсгийн 1385м, 1400м, төвийн хэсгийн 1385м, 1400м ашиглалтын түвшингүүдээс хөрсний овоолго хүртэл хөрс тээвэрлэх • Овоолго дээр буулгасан хөрсийг ажил гүйцэтгэгч компани өөрсдийн эзэмшлийн гинжит бульдозероор түрж цэвэрлэх • “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн баталсан Ил уурхайн технологийн паспортын дагуу ажиллах • 2000 мян.м³ хөрс тээвэрлэх • Тээвэрлэлтийн дундаж зай 2.5 км
ТАВИГДАХ ШААРДЛАГА	
2.1 Чадвар	Өөрсдийн эзэмшлийн, технологийн паспортын дагуу ажиллах тээврийн хэрэгсэлтэй байх. Мөн тэдгээрийн найдвартай ажиллагааг хангах, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ хийх хүн хүч, техникийн нөөцтэй байх.
2.2 Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> • Гүйцэтгэгчийн авто өөрөө буулгагч нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ашиглагдаж буй үндсэн тоног төхөөрөмж болох 10м³, 12м³, 18м³ шанаганы багтаамжтай шууд утгуурт ЭКГ-10, ЭКГ-12К, Либхэпп R994В, R9350- экскаваторуудтай хосолж ажиллах боломжтой байх, • Экскаватор авто өөрөө буулгагчийн хослолыг дараах томъёогоор бодно. Үүнд: $\frac{q_a}{E \cdot \gamma \cdot K_3} \approx 3.0 \div 6.0,$ <ul style="list-style-type: none"> - q_a-авто өөрөө буулгагчийн даац, т - E-экскаваторын шанаганы багтаамж, 10-18 м³ - γ-чулуулгийн эзлэхүүн жин, т/м³, 2.45-2.5 - K₃-экскавациалтын коэффициент, 0.69-1.0

	<ul style="list-style-type: none"> • Авто өөрөө буулгагчийн тэвшний өргөн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ил уурхайд ашиглагдаж буй шууд утгуурт экскаваторуудын шанаганы өргөнөөс их байх, • Хөрс тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь 0,3 м-ийн өндрөөс буух экскаваторын шанаган дахь уулын цулын цохилтын хүчийг даахуйц байх, • Овоолгын паспортын дагуу овоолгын хамгаалалтын далангийн өндөр 1-1,5м байх ёстой бөгөөд хөрс тээвэрлэлтийг гүйцэтгэх тээврийн хэрэгсэл нь уг хамгаалалтын даланг давуулж хөрс буулгах чадамжтай байх, • Сард 250 мян.м3 -ээс дээш хөрс тээвэрлэх, • Овоолго цэвэрлэх өөрийн эзэмшлийн гинжит бульдозертой байх, • Техникийн гэмтэл, саатлыг шуурхай арилгах, засварлах шуурхай үйлчилгээний засварын багтай байх, • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэнтэй байх, • Гүйцэтгэгч нь 12 цагаар 2 ээлжээр тасралтгүй 24 цаг ажиллах техник, хүн хүчний бүрэн боломжтой байх, • Тээврийн хэрэгсэл нь хөрс ачилт, буулгалтын үеийн цохилт, нуралтаас жолоочийн бүхээгийг хамгаалсан тусгай тоноглол, хийцлэлтэй байх, • Тээврийн хэрэгсэл нь Олон улсын ISO 3471, Монгол улсын MNS 6278:2011 стандарт тус бүрийг хангасан байх.
2.3 Арга аргачлал	Гүйцэтгэгч нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн баталсан Ил уурхайн технологийн паспортын дагуу хөрс тээвэрлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх.
2.4 Бусад	Ажлыг гүйцэтгэх санхүүгийн чадамжтай байх. Татвар болон бусад төрлийн өр төлбөргүй байх. Техникийн шаардлага, арга аргачлалуудад дээрхээс бусад тохиолдолд олон улсад болоод Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм, дүрэм холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэх.
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ТАЙЛАН	
3.1 Ажлын хяналт, шалгалт	<p>Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан календарьчилсан төлөвлөгөө, холбогдох гэрээ болон техникийн даалгаврын дагуу гүйцэтгэж буй тухай захиалагч талаас томилсон мэргэжилтэн шууд хяналт тавьж ажиллана.</p> <p>Захиалагч нь шаардлагатай үед хэдийд ч гүйцэтгэгчийн тээвэрлэлтийн ажилтай танилцах эрхтэй ба ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ мэдээлэл гаргуулж авах эрхтэй.</p> <p>Гүйцэтгэгч нь захиалагчийн төлөөлөгч мэргэжилтнүүдэд хяналт шалгалт явуулах боломжийг саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.</p> <p>Бусад тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээнд тусгагдсаны дагуу мэдээ, мэдээллүүдийг нууцлах ба зөвхөн захиалагч талын энэхүү гэрээ, техникийн даалгаварт заагдсан төлөөлөгч мэргэжилтнүүдийн зөвшөөрлөөр бусад этгээдэд</p>

	үзүүлэх, өгөх, танилцуулах ёстой. Хяналт, шалгалтын ажлыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хариуцна.
3.2 Тайлан материал хүлээлгэн өгөх, ажил дүгнэх	<p>Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан календарьчилсан төлөвлөгөө, холбогдох гэрээ болон техникийн даалгаврын дагуу хяналтыг тавина.</p> <p>Захиалагч нь шаардлагатай үед хэдийд ч гүйцэтгэгчийн ажилтай танилцах эрхтэй ба ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ мэдээлэл гаргуулж авах эрхтэй.</p> <p>Захиалагч талаас гүйцэтгэгч талын ажлын гүйцэтгэлд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ил уурхайн цех шууд хяналт тавьж ажиллана.</p> <p>Гүйцэтгэгч тал гүйцэтгэсэн ажлын тайланг ээлж бүрийн дараа Захиалагч талын Ээлжийн дарга-уурхайн диспетчерт тайлагнана.</p> <p>Ажлын гүйцэтгэлийг маркшейдерийн хэмжилтээр дүгнэнэ.</p>
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА	
4.1. Ажил эхлэх	Ажил гүйцэтгэх гэрээний дагуу
4.2. Хугацаа	Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөөг урьдчилсан байдлаар бэлтгэж захиалагчид танилцуулан батлуулсны дараагаар ажлыг эхлүүлнэ.
АЖИЛ ДҮГНЭХ	
5.1. Ажлын гүйцэтгэл дүгнэх	Ажлын гүйцэтгэлийг маркшейдерийн хэмжилтээр баталгаажуулна.